

- Нийгмийн хөгжил	17.6	1.4	4.8	0.5
В. Аж үйлдвэр	56.4	4.6	31.2	4.1
Г. Хөдөө аж ахуй	51.9	4.2	28.9	3.8
Д. Байгаль орчин хамгаалал	10.2	0.8	6.6	0.9
Е. Удирдлагын хөгжил	59.1	4.8	27.2	3.5
Ё. Төлбөрийн балансыг дэмжих	451.7	36.8	389.2	50.8
Ж. Бусад	1.0	0.0	0.6	0.0
Дүн	1230.7	100.0	766.4	100.0

Амлагдсан зээл тусламжийн ашиглалтын түвшин доогуур байгаа нь сүүлийн жилүүдэд амалсан зээл тусламж үндсэндээ урт хугацааны төсөл хэрэгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэхэд харьцангуй урт хугацаа шаардлагатай байдагтай холбоотой. Үүний дээр дотоод зохицуулалт, бэлтгэл хангах ажлын үр дүн сайнгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

ХХ ЗУУНЫ ЭХНИЙ МОНГОЛ, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВ БАЙДЛААС

Ц.Цэрэнлхам

1.Оросын худалдааны иргэд монголд нэвтэрсэн нь.

Монгол, Оросын худалдааны харилцаа бүр эртний түүхтэй.1689 оны Нэрчүүгийн гэрээгээр Орос, Хятадын засгийн газрын хооронд худалдаа хийхийг албан ёсоор зөвшөөрсөн нь Монгол нутагт Оросын худалдаачид ирж суурьших эх үүсвэрийг тавьжээ. ХҮИИ зуунаас эхлэн Хятад цайг Оросоор дамжуулан Европд оруулах болсон нь Монголд Орос иргэд ирэх явдлыг улам түргэсгэв. XIX зууны I хагасаас оросын худалдаачид Өргөө зэрэг хот суурин газар төдийгүй хөдөө нутгаар ирж суурьших болов.Орос иргэдийн анхны суурьшигчид нь хуучин шүтлэгтнүүд голдуу байв. Дараа нь оросын худалдаачид ирж эхэлсэн байна. 1860 онд Өргөө хотноо Оросын анхны худалдааны пүүс нээгджээ. Дараа нь Улиастай, Ховд хотууд болон хошуу нутгуудаар тарж эхэлсэн байна. Ялангуяа 1911-1912 оны эргэлтийн дараа оросууд мэдэгдэхүйц олширчээ. 1912-1919 онуудад тэдний тоо 1500-5000 хүртэл өссөн байна. 1919-1920 оны тоогоор Өргөөд 3000, Ховдод 300, Хатгалд 150, Улиастайд 100, Заяын шавьд 100, Вангийн хүрээнд 60, Мөрөнд 50, Хангилицыцагт 40 орос иргэн аж төрж байсан байна. Монголд суурьшсан худалдаачид ихэвчлэн Бийск - болон Хиагт хотоос гаралтай байв. Газар зүйн байрлалтайгаа уялдуулан Бийск хотоос ирсэн. наймаачид нь голчлон баруун Монголд / Ховд, Улиастай болон түүний ойр орчмоор, Хиагт хотоос ирсэн нь Өргөө болон Заяны шавьд амьдарч байжээ.

Хөвсгөл нуур болон Сибирийн ойролцоох газруудад Эрхүү, Түнхэний хязгаараас ирсэн иргэд байлаа. Хятадуудыг бодвол оросууд олон жилээр суурьшин амьдрахаар шийдэж, орост байснаасаа илүү том байшин сууцуудыг барин амьдарч эхэлжээ. Эдний ихэнх нь гэр бүлийн хамт нүүдэллэн ирдэг байсан нь хятад иргэдтэй харьцуулбал ондоо юм. Хошуу нутгуудаар тарсан оросууд олон жилээр гэр, байшинд амьдран сууж байсан боловч байшин сууцаа орос маягаар барих сонирхолтой байлаа. Тэр үед Өргөөд олон тооны орос барилгууд баригдсан нь үүнтэй холбоотой. Орос маягийн байшингуудыг Заяын шавь, Хатгал, Мөрөн хотуудад ч бас баригдаж байв.

Монгол оронд Оросын иргэд орж ирсэнтэй холбогдуулан тэдний сонирхол, эрх ашгийг хамгаалсан албан газрууд бий болов. Оросын засгийн газар 1860 онд Ар Монголын Их Хүрээнд анхны консулын газрыг байгуулжээ. Өргөө, Улиастай, Ховд, Хиагт дахь Оросын консулын газар, Монгол, Оросын худалдааг хөгжүүлэхэд онцгой анхааран тус оронд байсан Оросын харъяат нарын үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг байжээ. Ялангуяа хятадын цайг худалдан авах, Оросоос ангийн үс, цэмбэ, даавуу зэргийг Хиагт, Их Хүрээ, Чуулалт хаалга, Бээжингээр дамжуулан Хятадад гаргахыг онцгойд үзэж туслан дэмждэг байжээ. Оросын бүх консулын газрууд цахилгаан утас хүлээж авдаг байсан нь оросын иргэд дэлхий ертөнц дээр болж буй үйл явдлыг мэдэх цорын ганц суваг нь байлаа.

1915 оны намар хаант Оросын засгийн газар Нийслэл хүрээнээ суугч консулын газрыг ерөнхий консулын газар болгосон бөгөөд энэ үед Оросын дэд консулын газар Ховд /1905/, Улиастай /1911/, Хиагт /1916/-д байжээ.

Мөн С.Ю.Виттегийн санаачилгаар Оросын засгийн газраас Алс Дорнодын Орос-Хятадын банкны /1895-1910/ салбарыг Өргөө, Улиастай хотуудад байгуулжээ. 1910 онд Орос-Хятадын банк шинээр, Орос-Азийн банк болж өөрчлөгдөхөд Монголд өөрийн салбарыг нээсэн байна. Мөн Орос-Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банк гэж байв.

Дэлхийн I дайны эхээр Монголд байсан Оросын хувийн худалдаа хүчээ авч чадаагүй байсан учраас дайны нөхцөлд монголын малын мах, зарим түүхий эд онцгой шаардлагатай болж Орос, Монголын худалдааг өргөжүүлэх арга замыг хайж эхлэв. Энэ үед /1915 онд нэрт жуулчин хурандаа П.К.Козловын экспедицийг Оросын засгийн газар илгээв. Энэ байгууллага :4 жил Монголд байсан бөгөөд /1915-1918 Орост зориулж үхэр болон хонь худалдаж нийлүүлэх ажлыг эрхэлж байжээ. 1915 онд Монголоос 14000 бод мал, 1916 онд 93000 бод мал, 1917 онд 80000 бод мал, 1918 онд 50000 бод мал болон 60000 хонь Оросод гаргажээ.

Орос, Монголын худалдаа өргөжихийн хамт Хаант Монгол улсад орчин үеийн зарим соёл, үйлчилгээ нэвтрэв. Орос иргэд ихээр

төвлөрсөн газруудад шуудан, холбоо болон соёл үйлчилгээний зарим газруудын эх үүсвэр тавигджээ. Өргөөд их эмч, бага эмчтэй больниц ажиллаж эхлэв. Улиастай, Ховд, Хатгал, Заяын шавьд бага эмч бүхий эмийн сан хүртэл ажиллаж байв. Өргөө болон Хатгалд тахал эсэргүүцэх зорилго бүхий мал эмнэлгийн 2 салбар байжээ. Ардын боловсролын салбарт хэд хэдэн дэвшилтэт эхлэл тавигдав. Өргөө хот дахь консулын газрын дэргэд орчуулагчийн сургууль байгуулагдав. Мөн энд бага сургууль, худалдааны дунд сургууль бий болов. Улиастай, Ховд, Улаангомд Орос иргэдийн хүүхдийг сургах зорилготой бага сургуулиуд байлаа. Мөн Өргөөд Орос-Монголын хамтарсан хэвлэх үйлдвэр байсан бөгөөд тухайн үед Монголд монгол хэлээр унших ганц сонин болох «Нийслэлийн сонин бичиг»-ийг хэвлэдэг болжээ. Мөн монгол оросын жижиг үйлдвэрийн газрууд байгуулагдсан байна. Үүнд: Орхоны Эрэг дэх арьс ширний завод, Нийслэл хүрээнд дэх арьс ширний завод, модон завод, малын гэдэс дотор боловсруулах завод, савангийн үйлдвэр, жимсний ус үйлдвэрлэдэг газар, туйпууны завод, архины завод түүнчлэн ноос угаах олон тооны газрыг хэлж болно. Ноос угаалгын газрууд Улиастай, Идэрийн гол, Дэлгэр мөрний хавь газраар, Орхон голын хөвөөнд дэх Дайчин вангийн хүрээ, Их Хүрээний Туул гол дээр гэхчилэн газарт байжээ. Хаант Орос улсыг төлөөлөн хүрээнд сууж байсан худалдаа, үйлдвэрийн төлөөлөгчийн гаргасан тодорхойлолтыг иш татвал, Нийслэл Хүрээнд дэх бараа таваарыг бөөнөөр буюу жижиглэн худалдаалах хоршоо дэлгүүр 18, цагаан идээ наймаалах газар 26, түүхий эдийн бааз 8, эмийн сан 2, цаг, шил, элдэв эрдэнийн чулуу зарах пүүс 2, талх, чихэр, бурам, мах, архи, чихрийн дэлгүүр арваадыг Оросын худалдаа, үйлдвэрийн хүмүүс өмчилөн эрхэлж байлаа. Нийслэл Хүрээнд 3 ресторан байсны «Биржа», «Русь» хэмээх хоёр рестораныг орос хүн эрхэлж байв. Мөн Өргөөд 1903 оны зун «Оросын клуб» хэмээх соёлын газар нээгдсэн байна. Монда-Хатгал-Улиастай болон Ховд-Кош-Ашгийн хооронд шуудан цахилгааны тогтмол харилцааг дөнгөж 1915 онд тогтоосон. Хаалганы хооронд оросын шуудан 1863 оноос, цахилгаан холбоо 1897 оноос үйлчилж эхэлсэн юм.

2. Монголд байсан Орос худалдааны пүүсүүд

XX зууны үед Монголд Оросын нэлээд олон пүүс байжээ. Ховд дахь хамгийн том пүүс бол Бийскийн худалдаачин Н.И.Аскановын пүүс юм. Түүний Монгол дахь гүйлгээ нь 300 000 рубль болж байв. Энэ пүүс Монгол дахь Томскийн экспедицийг санхүүжүүлсэн ба Бийскийн худалдааны сургуулийг байгуулсан юм. Мөн Ховдын Орос худалдаанаас Аскановын пүүсээс гадна Байдаровын гэх мэт нэлээд том пүүсүүдийг нэрлэж болно. Эдгээр

пүүс худалдаа эрхлэхээс гадна мөнгө хүүлэх үйл ажиллагааг явуулж байв.

Одоогийн Увс аймгийн Баруун Туруун сумын нутагт Я.Е.Мокины, И.Д.Гуляевың гэсэн хоёр фактори байсан. Бийскийн худалдаачин Я.Е.Мокины пүүс Монголын баруун хэсэгт 1871 оноос ажиллаж эхэлсэн байна. 1910 онд 40 ажилчинтай байсан энэ пүүсийн үндсэн капитал хэдэн зуун мянган рубль болж байв. Пүүс жилд бод мал 2 мян. толгой, бог мал 6 мянган толгойг, ноос 8 мян.пүүг худалдан авдаг, өөрийн харъяа ноос угаах газартай байжээ./1-232/. Ховд дахь Ф.И.Кузнецовын пүүс монголчуудад голдуу мөнгө зээлдүүлж, тэднээс түүхий эд худалдан авдаг байсан байна. XIX зууны 40-өөд онд Германаас ирж Оросын харъяат бологчид Вогади И К-ийн пүүсийг байгуулсан бөгөөд XX зууны эхээр Оросын цайны бүх худалдааны 1/3 нь энэ пүүсийн мэдэлд байв. 1870 оноос энэ пүүс үйлдвэрлэл эрхлэх болов. 1916 онд худалдаа, үйлдвэрлэлийн 20 салбартай, 51 сая рублийн сантай томоохон концерн болсон байна.

XX зууныг гартал Монгол оронд жижиг ба дунд зэргийн пүүсүүд зонхилж байсан юм. XX зууны эхээр Баруун Монголд томоохон пүүсүүд, бий болж үлэмжхэн хэмжээний ноос, хонины нэхий, үхрийн шир, ангийн үс авдаг болжээ. Тэр үед зөвхөн Мөрөнд л гэхэд Оросын 5 пүүс «Козовин и Басов», «Баязитов и Комаров», «Шергин, Стухен и К», «Горбонос и К» зэрэг/ байв.1908 онд Москвагийн аж үйлдвэрийн районы фабрикийн эзэд оросын мануфактурыг Ойрхи ба Алс Дорнодын зах дээр гаргах зорилгоор «Русское экспортное товарищество»-г байгуулсан ажээ. Энэ байгууллагын салбарууд Перс, Турк, Афганистанд байгуулагджээ. 1912 онд түүний салбарууд Өргөө, Улиастайд нээгдэв. Мөн Бийскийн хамгийн эртний пүүсийн нэг А.Г.Бодуновын пүүс XIX зууны 70-аад оны эхээр Монголын баруун хойд нутагт нэвтэрч худалдаа хийж эхэлсэн байна. Энэ пүүс Монголд арав орчим салбартай болжээ. Нэгтгэсэн мэдээнээс үзвэл 1918-1919 оны байдлаар Өргөөд Оросын 50 орчим томоохон пүүс, Улиастайд 5 том пүүс, Ховдод 12, Улаангомд 3 пүүс тус тус байв. 1923 онд Монголд 2323 худалдааны фирм бүртгэгдсэний 166 буюу 7 хувь нь оросын хувийн фирм байлаа.

3.XX зууны эхний монгол-Оросын худалдааны хэмжээ, бүтэц

Монголд байсан худалдааны захууд нь бие биеэсээ онц ялгаагүй нэг төрлийн барааг худалдан авч, өгөлцөж байсан бөгөөд зөвхөн эргэлтийн мөнгөний хэмжээ нь өөр байв. Тэр үеийн монголын томхон төв нь Өргөө хот байв. Өргөө нь гадаад орнуудтай харьцах, дамжин өнгөрөх төв байсан бөгөөд гол нь Монгол-Орос-Хятадыг

холбож байлаа. Өргөө хотоор улсын гадаад худалдааны 3/4 хувь дамжин өнгөрч байжээ. Оросын худалдаачдын Монгол нутгаас цуглуулсан ноос болон бусад түүхий эдийг Өргөөд төвлөрүүлж эндээс Орос руу ачаалдаг байв. Өргөөд хотын бөөний барааны агуулахуудаас барааг худалдааны бусад салбаруудад тараадаг байлаа. Мөн энд жижиглэн худалдаалах цэгүүд олон байсан нь Ховд, Улиастайн захаас өвөрмөц байв.

Өргөө хотын захын дараа хэмжээгээрээ Улиастайн зах орж байв. Улиастай хотын захын онцлог нь хонь, тэмээний ноос худалдан авах гол төв байв. Улиастайн зах дээр барааг бөөнөөр нь хошууны мухлагуудад хуваарилаж, тэндээс жижиглэн худалддаг байжээ.

Улиастайн барааны эргэлт нь 1918-1919 онуудад жилд 3,5-4 сая рубльд хүрч байв. Улиастайн захын дараа Ховдын зах орж байв. Ховдын бараа эргэлт нь 1919 онд 2-2,5 сая рубль байлаа. Үүний дараа Хиагт, Хатгал, Вангийн хүрээ, Мөрөн, Улаангом хотын захууд орж байв. 1913 оны байдлаар Орос улс Монголоос авч байсан зүйлийг мөнгөн дүнгээр тооцвол бод, бог мал - 9 сая 650 мян.руб., хонь, тэмээний ноос, хонь ямааны болон хурганы арьс, бодын шир, адууны сүүл, тарваганы арьс зэрэг бүтээгдэхүүнийг авч байжээ. Харин Оросоос Монголд оруулж байсан зүйл нь гурил, будаа, элсэн чихэр, даавуу, даалимба, торго, төмөр ба ширэн эдлэлүүд байв. Үүнээс гадна бүрэн бус мэдээгээр үзвэл 1905 онд Орост тарваганы арьс I сая, түүнчлэн 1909 онд зөвхөн Хиагтын боомтоор 1353569 рублийн үнэ бүхий 1853767 ширхэг тарваганы арьс гарснаас нэлээд хэсэг нь Германд хүрч байв. 1891-1908 оны завсар Оросоос Монгол руу оруулсан бараа 22%-иар, Монголоос Орос руу гаргасан түүхий эд даруй 56%-иар тус тус өсч, 1899-1901 оны байдлаар монгол дахь оросын худалдааны гүйлгээ жилд 7 сая рубль, 1905 онд 8 сая рубльд хүрч байжээ.

1861 онд Оросын худалдаачдаас Монголд 100-аад нэр төрлийн 137 мянган рублийн бараа нийлүүлсэн байна. Эл бараа таваарын дотор элсэн чихэр, ётон, тамхи, төрөл бүрийн цаг, цагаан даавуунаас гадна, цонхны шил, толь, герман төмөр, гууль, тугалга хадаас зэрэг зүйлс оролцож байв. Мөн онд Монголоос хаант Орост 40 нэр төрлийн 74321 рублийн үнэ бүхий бараа таваар, түүхий эд гаргаж байсны дотор монгол эмээл мэт эдлэл, тарваганы арьс, хонины нэхий, ямааны арьс, адуу үхрийн шир багтжээ. XX зууны эхээр ялангуяа 1911 оноос худалдааны хэмжээ улам түргэн өсчээ.

1911-1915 оны Орос-Монголын
худалдааны байдал /мянган рублиэр /
/3-111-112/

Жил	Монголоос гаргасан хэмжээ	Монгол руу оруулсан хэмжээ
1911	757995	2114640

1912	2720000	3184043
1913	8403000	2689000
1914	8427000	4484000
1915	11451000	2429000

4.Монгол дахь Оросын хамтарсан үйлдвэрийн газрууд

Монголын ашигт малтмалыг гадаадынхан XIX зууны эцсээр нэлээдгүй сонирхож эхэлжээ. 1900 оны 1-р сарын 26-нд Түшээт хан, Сэцэн хан аймгийн нутаг дээр алтны уурхай ашиглах зорилгоор «Монголор» / »Монгол алт» гэдэг хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулагдсан байна. 1899 онд энэ концессыг Оросын хөрөнгөтөн фон Грот Манон гэгч 25 жилийн хугацаагаар түрээслэн авч, олон улсын хувь нийлүүлсэн нийгэмлэг болгожээ. «Монголор»-ыг үүсэхэд хувь нийлүүлсэн байгууллагууд гэвэл, «Золоторосс» хэмээх Оросын алтны уурхайн нийгэмлэг, Берлиний Мендельсон ба түүний компани, «Орос дахь үйлдвэрийн асуудал эрхэлсэн Ерөнхий хороо», «Санкт Петербургийн олон улсын банк», «Орос-Хятадын банк», «Парис Нидерландын банк», «Хятадын газрын баялаг ашиглах синдикат» гэх зэрэг томоохон нийгэмлэг, банк, синдикатууд байжээ.Хувь нийлүүлэгчид нь Оросын хатан хаан Мария Федоровна, Бельгийн хаан Леопольд, Манж чин улсын түшмэл Ли Хунчжан нар байжээ. «Монголор»-ын нийт орлого 1910 онд 2501691 рубль буюу 120 пүү алт болжээ. 1913 онд 38 пүүг олборлосон бол 1914 онд 18 пүү алт гаргасан байна. XIX зууны эцсээс эхлэн «Монголор» гэдэг нийгэмлэг 18 жил ажиллахдаа 10471000 мексик долларын үнэ бүхий 606 пүү алт олборлосон мэдээ бий. 1912 оны дундуур «Монголор»-ын зөвхөн нэг салбар Их Хараагын алтны уурхайд 800 шахам хүн ажиллаж байв.

1915 онд Оросын уулын инженерийн газрын удирдлагын дор Монголын засгийн газрын хүсэлтээр анхны уурхай нээгдлээ. Тэр үеэс 1,5 тонн хар нүүрсийг олборлож Өргөө хот руу тээвэрлэдэг байлаа. Уурхайд 160 м-ийн гүнтэй 2 цооног байжээ. 1919 оны зун энд 40 ажилчин ажиллаж байсан ба 1 пүү болгонд 0,06 лан мөнгөний цэвэр ашигтай байв.

5.Монгол-Оросын худалдааны гол замууд

XIX зууны Монгол-Оросын эдийн засгийн харилцаанд гол үүрэг гүйцэтгэж байсан замууд гэвэл:

1.Улаан даваа-Ховдын зам /400км/ Сибирээс Монгол оронд ирэх хамгийн баруун талын зам юм. Энэ зам нь Хотоноор дамжин Семипалатинск хүрдэг байлаа.

2.Холи-Агач-Ховд-400 км. Энэ замыг Үгүйн зам гэж нэрлэдэг байсан. ХХ зууны эхээр Үгүйн замыг нэлээд засварлаж сайжруулсан боловч уулархаг газар учраас тээвэрт нэлээн хүндрэл учруулж байв.

3. Белопарск /Одоогийн Туваагийн нийслэл Кизил хот / -Харилцаг -Улиастай-700 км. Энэ нь тэр үедээ шинэ зам байсан юм. Улиастай, Енисейг холбосон энэ зам ачаа тээвэрлэхэд нэлээн хөнгөн байжээ. Энэ замын үргэлжлэл нь Белоцарск-Минусинск-Красноярск ордог.

4.Монд-Хатгал-Улиастай-600 км. Энэ замын үргэлжлэл нь Монд-Түнхэн-Култун-Иркутск ордог байжээ. Ойролцоогоор 400 км. Түнхэн Хатгалын хоорондох зам маш хэцүү байсан. Харин Хатгалаас Улиастай хүрэх зам арай дээр байжээ.

5.Хиагт-Өргөө-350 км. Энэ замын үргэлжлэл нь одоогийн Улаан-Үд гол ба өвөлдөө Сэлэнгийн мөсөн дээгүүр, зундаа усан онгоцоор гаталж байжээ. Хиагт-Өргөөгийн зам нь муу биш, гол хүндрэл нь Манхтайн намагтай газар таардаг учраас тойрч гарах явдал юм.

6.Манжуур-Өргөө-1000 км. Энэ нь тэмээн жинд тохиромжтой сайн зам юм. Өргөөгөөс 200 км газар Зүүн хүрээний ойролцоо Хэрлэн голыг дайран Бэрээвэн хийдийн хажуугаар Улз гол ордог энэ зам нь 450 км үргэлжилсэн бөгөөд нэг ч уул нуруу дамжилгүйгээр Манжуур ордог автомашинд тохиромжтой зам байжээ.

ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГЭЭС СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ХЭВЛҮҮЛСЭН НОМУУД.

1.1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс их гүрнүүдийн харилцаа. «Хүйтэн дайн»-ы эрин төгсгөл болсон сүүлийн жилүүдэд олон улсын харилцаанд зарчмын шинж чанартай өөрчлөлтүүд гарч шинэ тогтолцоонд шилжин хэв загвараас ангижирч, үндэсний эрх ашгийг дээдэлсэн прагматик шинж чанартай болж манай улсын үндэсний эрх ашгийг дээдэлсэн зэрэг Ази, Номхон далайд төдийгүй дэлхийн бодлогод нөлөөтэй улс орнууд тодорхой байр суурь эзлэх болсон болон мөн урд хөршийн бүс нутагт үзүүлэх нөлөө нэмэгдэж байгаатай уялдан Америк-Хятад, Япон-Хятадын харилцаа ч Монголын гадаад орчинд ямар нэг хэмжээгээр учир холбогдолтой болсон юм. Тус номонд Ази, Номхон далайн бүс нутгийн дөрвөн их гүрэн АНУ, БНХАУ, ОХУ, Японыг сонгон авч их гүрэн тус бүрийн бодлого, түүнд илэрч буй шинэ хандлагууд, тэдгээр орнууд ба Монгол улсын харилцаа, ялангуяа хоёр талын харилцаанд 90-ээд онд бий болсон шинэ хүчин зүйлс хоёр талын харилцааг эрчимжүүлэх арга замыг тодорхойлсон байна.

2. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. Энэ номонд Их Монгол улс байгуулагдсанаас эхлэн Монголын эзэнт гүрний төгсгөл үеийг хүртэл Монгол Улсын гадаад харилцааг шинэлэг санаа